# САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЭРДЭНЭЦОГТ ОВОГТОЙ ГАНПҮРЭВИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>ЗГҮАХ 2.1.12.1, ЗГҮАХ 2.1.12.3, ЗГҮАХ 2.1.12.4 Эрүүл мэндийн салбарын Барилга байгууламжийн шилжих 44, шинэ 34 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжилтийг ханган гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ. /МУ-ын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын / XVIII.1.1-XVIII.1.78/ | Санхүүжилтийн хувь | 90% | Батлагдсан төсвийн хүрээнд гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ. | Эрүүл мэндийн салбарын Барилга байгууламжийн шилжих 78 төсөл, арга хэмжээний 200.3 тэрбум төгрөгөөс 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 85.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоод байна. 42.6%<br>/Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжээгүй 40 төсөл, арга хэмжээний 150.1 тэрбум төгрөгөөс 66.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон./ 44.5% | 1-12 сар | 100% |
| 2. | Арга хэмжээ 1.2<br>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээнүүдийг барилгын тухай хууль болон төрийн болон орон нутгийн өмчийн | 16 гэрээ байгуулах | 44 | 16 гэрээ байгуулсан байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нэмэгдэж батлагдсан Эрүүл мэндийн сайдын багцаас орон нутагт эрх шилжээгүй 16 төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээ байгуулсан. | 1-3 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. ЗГҮАХ 1.1.3.5, МУТЖҮЧ-2.2.1, МУХТ 1.1.3.5, Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна. | Төсвийн төсөлд тусгах санал боловсруулах | Батлагдсан ТЭЗҮ | Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн байна. | "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн төлөвлөлтөд “Өвчний хяналт, сэргийлэлтийн төв” байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчээр “Эм Си Эс Си” ХХК болон “Солармед Монгол” ХХК-ийн түншлэл шалгаран гэрээ байгуулсан. Гадна инженерийн шугам, сүлжээний газар, шороомы ажил, барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан, байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 25%-тай байна. | 4-12 сар | 100% ✓ |
| 4. | Арга хэмжээ 1.4. ЗГҮАХ 2.1.3.1 Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах | Батлагдсан ТЭЗҮ | Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” төсөвт өртөг нь 140.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 42.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр “Магнуссентурион Констракшн” ХХК болон “Сетунари” ХХК-ийн түншлэл шалгаран 140.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Газар шороо, гаражийн барилгын суурь, 1 давхарын цутгалтын ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 10%-тай байна. | 1-12 сар | 100% ✓ |
| 5. | Арга хэмжээ 1.5. ЗГҮАХ 2.1.3.2 Зүрх судасны төв байгуулна. | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах | Батлагдсан ТЭЗҮ | Зүрх судасны төвийн гадна инженерийн шугам, сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд “Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо/” төсөвт өртөг нь 2.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 1.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг 7 удаа зарласан, 5 удаа оролцогч санал ирүүлээгүй 2 удаа шаардлага хангасан оролцогч санал ирүүлээгүй. | 1-12 сар | 100% 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ЕСБХБанкны хөнгөлөлттэй зээлээр “Зүрх судасны үндэсний төв”-ийн барилгын төслийг санхүүжүүлэхээр 2024.09.30-ны өдөр МУ-ын ЭЗХЯам, СЯ, ЭМЯ болон ЕСБХБанк хамтарсан DTM55677 дугаартай “Санхүүжилтийн өмнөх гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний дагуу 120 ортой тусгай зориулалтын ЗСҮТөвийн барилга барьж ашиглалтад оруулах төслийн нийт өртөг 51,0 сая ам.доллар байх ба ЕСБХБанк нь 30,0 сая ам.долларыг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ. Тоног төхөөрөмжийн нийт өртөг 21,0 сая ам.доллар байх ба улсын төсөв болон Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэхээр тооцоолсон. Мөн ЕСБХБанкны “Техникийн хамтын ажиллагааны сан”-аас төслийн “Техник эдийн засгийн үнэлгээ”, – “Байгаль орчин, нийгмийн үнэлгээ”, “Худалдан авалтын үйл ажиллагаанд түр хугацааны дэмжлэг үзүүлэх”, “Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих” зэрэг үйл ажиллагаанд 1,1 сая еврогийн буцалтгүй тусламжийг үзүүлнэ. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. ЗГҮАХ 2.1.3.3 Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах | Батлагдсан ТЭЗҮ | Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн төлөвлөлтөд 60 ортой Сүрьеэгийн тасаг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчээр “Эм Си Эс Си” ХХК болон “Солармед Монгол” ХХК-ийн түншлэл шалгаран гэрээ байгуулсан. Гадна инженерийн шугам, сүлжээний газар, шорооны ажил, барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан, байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 25%-тай байна. | 1-12 сар | 100% |
| 7. | Арга хэмжээ 1.7. ЗГҮАХ 2.1.3.4 Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | 80% | Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна. | Барилга угсралтын ажлын зураг төсөл, төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нь нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2022, 2023 оны | 1-12 сар | 90 95% |

195

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсвийн тухай хуульд тусгуулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/”-ын ажлыг дуусган Геронтологийн төв болгон ашиглахаар төлөвлөж байна. Ажлын гүйцэтгэл 95%-тай явж байгаа бөгөөд улсын комисс ажиллуулах хүсэлтээ өгсөн. 2024 оны 12 дугаар сарын 2 дугаар 7 хоногт ажиллах улсын комиссын хуваарьт оруулахаар ажиллаж байна. | | |
| 8. | Арга хэмжээ 1.8. ЗГҮАХ 2.1.3.6 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна. ш/үзүүлэлт батлагдсан төлөвлөгөөнөөс өөр | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хувь | Батлагдсан ТЭЗҮ | Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчээр “Эм Си Эс Си” ХХК болон “Солармед Монгол” ХХК-ийн түншлэл шалгаран гэрээ байгуулсан. Гадна инженерийн шугам, сүлжээний газар, шорооны ажил, барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан, байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 25%-тай байна. | 1-12 сар | 100% |
| 9. | Арга хэмжээ 1.9. ЗГҮАХ 2.1.3.7 Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна. | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хувь | Батлагдсан ТЭЗҮ | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | Хавдар судлалын үндэсний төв-2 цогцолбор байгуулах зориулалтаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Чулуутын аманд 10 га газар олгогдож, зураг төслийг БХБЯаманд захиалж, 2021 оноос зураг төсөл, төсөв боловсруулах гэрээ байгуулагдсан боловч, зургийн ажлын явц 30 хувьтай байна.<br>Ажлын зураг төсөл, төсвийн гүйцэтгэгч "Хот Төлөвлөлтийн Хүрээлэн" ХХК 996.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч загвар зураг батлагдсаны дараа тухайн гэрээний дүнгээр гүйцэтгэх боломжгүй 3,800.0 сая төгрөгөөр гүйцэтгэх тухай санал ирүүлж, зөвшөөрөхгүй тохиолдолд гэрээ цуцлах хүсэлт гаргасан. Гүйцэтгэгчийн саналыг захиалагч Барилга, хот байгуулалтын яамнаас судлан 3,800.0 сая төгрөг биш нэмэлт 3,000.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоолол гарган | 1-12 сар | 80% |

98

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад хандсан. 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн “Жагсаалт батлах тухай” А/12 дугаар тушаалаар нэмэлт хөрөнгө шийдвэрлэж, Эрүүл мэндийн яамнаас худалдан авах ажиллагааг зарлуулахаар Төрийн Худалдан авах ажиллагааны газарт холбогдох мэдээллийг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2/1692 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр “Бодь пропертийз” ХХК болон “Төгс гранд констракшн” ХХК-ийн түншлэл 2,400.0 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулсан.<br>УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 3.3.2.3. “Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II”-ын барилга барих гэж 20,000.00 сая төгрөг тусгагдсан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Хавдар судлалын үндэсний төв-2 төсөл арга хэмжээнд 10,000.0 сая төгрөг батлагдсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг ханган, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д төсөл, арга хэмжээг үүсгээд байна. | | |
| 10. | Арга хэмжээ 1.10.<br>ЗГҮАХ 2.1.3.8 Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах | - | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “Эмнэлгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо/” төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 40.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 5.0 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд Засгийн газрын 2023 оны “Жагсаалт батлах тухай” 409 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/12 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн. Нийслэлээс худалдан авах ажиллагааг 2024.04.18-ны өдөр зарласан боловч “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар”-т гомдол гарч, худалдан авах ажиллагаа түр зогссон | 1-12 сар | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байсан нь шийдвэрлэгдсэн. Дахин зарласан тендерийн нээлт 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр болж оролцогч санал ирүүлээгүй тул амжилтгүй болсон. | | |
| 11. | Арга хэмжээ 1.11.<br>ЗГҮАХ 2.1.11 Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг үе шаттайгаар байгуулна. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | 80% | Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна. | Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилгын барилга угсралтын ажил дууcч "Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын акт" баталгаажсан.<br>**Нэмэлт:** "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл"-ийн хүрээнд Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил 50% нүйцэтгэлтэй байна. | 1-12 сар | 100% |
| 12. | Арга хэмжээ 1.12.<br>ЗГҮАХ 2.1.14 Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно. | Ашиглалтад орсон эрүүл мэндийн төвийн тоо | 33 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга 38 батлагдсан.<br><br>Дээрх тусгагдсан шилжин хэрэгжих 2024 онд дуусах төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга 38 батлагдсанаас 14 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга ашиглалтад ороод байна. Үлдсэн 24 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилгаас<br>➢ Худалдан авах ажиллагааны шатанд 4<br>➢ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 5<br>➢ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 4<br>➢ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 2<br>➢ 0-29 хувийн гүйцэтгэлтэй 9 | 1-12 сар | 80% |
| 13. | Арга хэмжээ 1.13. | Ашиглалтад орсон | 64 | Монгол Улсын 2024 оны | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд барилга байгууламжийн 78 төсөл, арга хэмжээ | 1-6 сар | 100% |

102

129.5%

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ 2.1.12 Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | барилга байгууламжийн тоо | | төсвийн тухай хуульд тусгагдсан шилжин хэрэгжих 2024 онд дуусах төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулах, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | батлагдсанаас 23 барилга байгууламж ашиглалтад ороод байна. Үлдсэн 55 барилга байгууламжаас<br>➢ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 11<br>➢ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 9<br>➢ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 3<br>➢ 0-29 хувийн гүйцэтгэлтэй 22<br>➢ Худалдан авах ажиллагааны шатанд 10 байна. | | |
| 14. | Арга хэмжээ 1.14.<br>Эрүүл мэндийн салбарт хэрэгжих хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгох, тайлагнах | Хөтөлбөр, зориулалтын тоо, зарцуулсан мөнгөн дүн | 42,455.5 сая төгрөг | | Захиалагчийн хяналт тавьж буй "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-аас баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийг хянан баталгуулж, 66.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон. | 1-12 сар | 100% ✓ |
| **Зорилт 2. "ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ"** | | | | | | | |
| 15. | Арга хэмжээ 2.1.<br>Эрүүл мэндийн сайдын багц, 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны батлагдсан төсөв | Батлагдсан хууль | Эрүүл мэндийн сайдын багц, сангийн 2025 оны батлагдсан төсөв | Төсвийн тухай хуулийн цагалбарын дагуу 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, нэгтгэн 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 1а/2514 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Уг саналд төсөвт өртөг нь 1,851.4 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 846.0 тэрбум төгрөгийн 121 төсөл, арга хэмжээний санал хүргүүлсэн. | 1-6 сар | 100% ✓ |
| 16. | Арга хэмжээ 2.2.<br>Эрүүл мэндийн сайдын багц, 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулна. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны | Батлагдсан хууль | Эрүүл мэндийн сайдын багц, сангийн 2025 оны батлагдсан төсөв | Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах" тухай 278 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар бэлтгэл ажлыг хангаж төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем https://pimis.publicinvestment.gov.mn/-д холбогдох мэдээллийг оруулан Улсын Их Хурал, Сангийн | 1-12 сар | 100% ✓ |

194

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | батлагдсан төсөв | | | яам, Үндэсний аудитын газарт 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 1а/3042 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | | |
| **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ”** | | | | | | | |
| 17. | Арга хэмжээ 3.1.<br>“Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг барих” төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих | Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан | 5% | 40% | Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголтын банк хоорондын 2019 оны Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг барих” төслийг хэрэгжүүлэх 43,2 сая ам.долларын зээлийн хэлэлцээр, 5,0 сая еврогийн буцалтгүй тусламжийн гэрээ болон Төслийн гэрээ байгуулагдсан.<br>Европын сэргээн босголтын банкнаас Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилга барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) хийх "Green engineering and Finance" зөвлөх компани сонгон шалгаруулж, 29,841 м2 талбайтай, хэвтэн эмчлүүлэгчийн 250 ортой, 33 эмнэлгийн үндсэн нэгж бүхий нэгдсэн эмнэлэг барих ТЭЗҮ боловсруулагдсан.<br>Сангийн яаманд ТХН байгуулах тухай хүсэлт хүргүүлж, Сангийн сайдын 2024.05.28-ны 96 дугаартай “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” тушаал батлагдсан.<br>ЭМЯ-наас “Төслийн гэрээ”-нд хууль зүйн дүгнэлт гарган, 2/117 дугаартай албан бичгээр ЕСББанкинд хүргүүлсэн.<br>Дархан НЭ-ийн ТЭЗҮ-ийн байгаль орчны үнэлгээнд дүгнэлт гаргуулахаар БОАЖЯам болон Дархан-Уул аймгийн БОАЖГазарт 2/2414, 2/2415 дугаартай албан хүсэлт хүргүүлсэн.<br>ТЭЗҮ-тэй хамт хийгдсэн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй танилцаж, Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт” 2024 оны 06 дугаар сарын 04-нд гарсан.<br>ЭМЯ-ны ТНБДаргын 2024.07.26-ны өдрийн А/95 тушаалаар тус төслийн PIS болон PIU сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан.<br>13. ЭМС-ын 2024.07.26-ны өдрийн А/337 тушаалаар ““Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг | 1-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барих тухай" төслийн Төслийн удирдах хороо байгуулагдсан.<br>"Төслийн хэрэгжилтийн зөвлөх" PIS-ийн сонгон шалгаруулалтыг ЕСББанкны журмаар ECEPP системээр, "Төсөл хэрэгжүүлэгч нэгж"-ийн PIU-ийн сонгон шалгаруулалтыг Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдаж байна. ТХН-ийн 7 ажлын байрыг 2 зарласнаас 3 ажлын байрны сонгон шалгаруулалт амжилттай болж, 4 ажлын байрны сонгон шалгаруулалтын дахин зарласан. 2024.12.13-нд материал хүлээж авч, үнэлгээ хийгдэнэ.<br>"Төслийн хэрэгжилтийн зөвлөх" PIS-ийн материалыг 2024.11.25-нд хүлээн авсан бөгөөд 2оролцогч санал ирүүлсэн. Үнэлгээ хийгдэж байна. | | |
| 18. | Арга хэмжээ 3.2.<br>"Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төсөл" төслийн хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллах, хяналт тавих | Хэрэгжилтийн хувь, Хийсэн ажлын тайлан | 60% | 85% | 1-р үе шатны төслийн хүрээнд хийгдсэн ажлууд:<br>1. Сумын эрүүл мэндийн төвүүдийн (СЭМТөв - 4: Хөвсгөл аймаг - Тариалан СЭМТ, Өвөрхангай аймаг - Баян-Өндөр СЭМТ, Дорноговь аймаг - Эрдэнэ СЭМТ, Булган аймаг - Дашинчилэн СЭМТ) барилгын ажлын гүйцэтгэл - 35-92% байна.<br>2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн (ӨЭМТөв - 2: БЗД-ийн 17-р хорооны ӨЭМТ, ЧД-ийн 19-р хорооны ӨЭМТ) барилгын ажлын гүйцэтгэл 3-10% байна.<br>3. Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлж, угсарч суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийн гэрээ хийгдсэн, тоног төхөөрөмжүүд тээвэрлэлтийн шатандаа явж байна.<br>4. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийн гэрээ байгуулагдсан. Барилгын ажлын гүйцэтгэл 19%-тай байна.<br>5. Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажил 50% нүйцэтгэлтэй байна.<br>6. Түргэн тусламжийн үндэсний төвийн барилгын ажлын зураг дуусах шатандаа явж байна.<br>7. Төслийн хүрээнд 37 зөвлөх үйлчилгээг гэрээлсэнээс 5 гэрээ дууссан. Нийт 252 удаагийн сургалтаар 6212 хүнийг сургасан.<br>2-р үе шатны төслийн зээлийн гэрээг АХБ болон МУЗГ хооронд 2024 оны 11-р сарын 20-нд зурагдсан. | 1-12 сар | 100% |

| Зорилт 4. ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН БУСАД ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН БОЛОН НЭГЖИЙН ДОТООД АЖИЛД ОРОЛЦОХ, УДИРДЛАГААС ХУУЛЬ ЁСНЫ ХҮРЭЭНД ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ БИЕЛЭЛТ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19. | Арга хэмжээ 4.1<br>Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | Боловсруулсан мэдээллийн тайлан | - | Шаардлагатай тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргасан байна. | ➢ “Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө”-ний боловсруулахад оролцож, бусад газар, хэлтэстэй хамтран ажилласан.<br>➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн болон 2024 онд хэрэгжүүлэх томоохон ажлын танилцуулга, мэдээ бэлтгэсэн.<br>➢ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний задаргаанд тусгуулах, Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлж батлуулсан.<br>➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн, 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг нийслэл, аймаг бүрээр гаргасан.<br>➢ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2023 оны жилийн төлөвлөгөөнд хийгдсэн аудитад холбогдох мэдээлэл, судалгааг гаргаж өгсөн.<br>➢ “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын хүрээнд холбогдох мэдээлэл, судалгааг гаргаж өгсөн.<br>➢ Барилга, хот байгуулалтын сайдын “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 2024 оны 95 дугаар тушаалд хамаарагдан тарифт цалинг шинэчлэн тооцох шаардлагатай төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг гарган “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүргүүлсэн.<br>➢ Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг нэгтгэн Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөвт өртгийн нэмэгдэл үүссэн төсөл, арга | 1-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээний мэдээллийг гарган Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023, 2024 онд Эрүүл мэндийн яамнаас худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн. | | |
| 20. | Арга хэмжээ 4.2<br>Албан бичиг, өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, ажлын цагийг мөрдөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь | - | Албан бичиг, өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, ажлын цагийг мөрдөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэн ажилласан байна. | Тайлант хугацаанд иргэн, ААНБ-аас 498 албан бичиг ирсэн. Үүнээс:<br>➢ Шийдвэрлэсэн албан бичиг 457<br>➢ Судалж байгаа албан бичиг 41<br>Чиг үүргийн хүрээнд төрийн байгууллага, иргэн, ААНБ-д 252 албан бичиг хүргүүлсэн. | 1-12 сар | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1.<br>Мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалт, семинарт оролцох | Сургалт, семинарын тоо | 4 | 2 | ➢ Сангийн яамны зохион байгуулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сургалтад хамрагдсан.<br>➢ Удирдлагын академиас зохион байгуулж буй Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн.<br>➢ “Төрийн бүтээмжийн сэргэлт-цахим эрүүл мэнд” | 1-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдэвт сургалт, "Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал" сургалт хамрагдсан.<br>➢ Худалдан авах ажиллагааны А3 гэрчилгээ олгох сургалтад хамрагдсан.<br>➢ Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтуудад тухай бүр zoom аппликейшнээр холбогдож хамрагдсан. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Төрийн албаны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг судлах | Эрүүл мэндийн салбарын эдийн засаг, төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг бие даан судлах | 3 | Эрхэлсэн ажлынхаа хүрээнд холбогдох хууль, дүрэм, журам, шинэчлэгдэх бүрд судлан мэдлэгээ дээшлүүлнэ. | Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд хамаарах шинээр батлагдан гарсан болон шинэчлэн найруулсан хууль тогтоомж, дүрэм журмыг судлан ажилдаа мөрдөн ажиллаж байна. | 1-12 сар | Хасах<br>100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Барилгын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн ............................................. /Э.ГАНПҮРЭВ/ 2024. 12. 05

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*